

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6-13
<hr/>	
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/	6
2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 4 гишүүн 2022.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	6-13

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 05 дугаар
сарын 03-ны өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны
товч тэмдэглэл**

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 45 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилоттой: Б.Бейсен, Б.Энхбаяр;

Чөлөөтэй: Ш.Адъяа.

Хуралдаанд Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар оролцов.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Баттөмөр: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 2

Бүгд: 6

66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 4 гишүүн 2022.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, мөн зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын хүний нөөцийн газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сувдмаа, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх Ажлын албаны дарга Д.Дуламсүрэн, Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор А.Алтанзул, Монгол Улсын Их сургуулийн зөвлөх профессор Р.Дарьхүү, мөн сургуулийн багш, дэд профессор Д.Оюунгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Байнгын хорооны дарга Б.Баттөмөр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан нарын тавьсан асуултад Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор А.Алтанзул, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын хүний нөөцийн газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сувдмаа нар хариулж, тайлбар хийв.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Баттөмөр: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг гуравны хоёроор дэмжих нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 2
Бүгд: 7
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгах санал:

Б.Баттөмөр: 1.Төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.2 дахь хэсэг нэмэх:

“9.2.Улсын Их Хурал төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг баталж, мөрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 3
Бүгд: 7
57.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Баттөмөр: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 2
Бүгд: 7
71.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Баттөмөр: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 2
Бүгд: 7
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Энэ санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 11 дүгээр зүйлийн 11.6.1 дэх заалтын “бодлого” гэсний дараа “, үндэсний хөтөлбөр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 2
Бүгд: 7
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Засгийн газар нь” гэснийг “Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь” гэж, “Ёс зүйн дэд хорооны” гэснийг “энэ хуулийн 13.3-т заасан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 2
Бүгд: 7
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтын “төрийн албанаас” гэсний өмнө “Төрийн албаны тухай хуульд заасны дагуу” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 2
Бүгд: 7
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 20 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 3
Бүгд: 7
57.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Баттөмөр: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 2
Бүгд: 7
71.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Баттөмөр: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баделханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Батгөмөр: Улсын Их Хурлын гишүүн Х.Баделханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 2

Бүгд: 7

71.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Батгөмөр: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 2

Бүгд: 7

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Б.Батгөмөр: Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “ажил хэргийн санаа бодлыг үл хүндэтгэх” гэснийг “ажил хэрэгч саналыг үл хайхрах” гэж, 8.1.5 дахь заалтын “хясан боогдуулахгүй” гэснийг “хязгаарлахгүй” гэж, 8.2.3 дахь заалтын “мэдээллийг бусдад дамжуулах” гэснийг “мэдээллээр бусдыг” гэж, төслийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтын “Дэд хорооны” гэснийг “энэ хуулийн 15.1.5-д заасан” гэж, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын “тухайн албан хаагчийг дуудан ирүүлж,” гэснийг “тухайн албан хаагчаас биечлэн” гэж тус тус өөрчлөх, төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “10.1.” гэсний дараа “, 10.2” гэж нэмэх, төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Батгөмөр: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 2

Бүгд: 7

71.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Б.Баттөмөр: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 2
Бүгд: 7
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

Б.Баттөмөр: Төслийн 2 дугаар зүйлийн “37 дугаар зүйлийн 37.1.7,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 2
Бүгд: 7
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 35 минут үргэлжилж, 10 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 70.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАТТӨМӨР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон
“Их засаг” танхим
10 цаг 45 минут.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023
ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ 05 ДУГААР
САРЫН 03-НЫ ӨДӨР /ЛХАГВА
ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Баттөмөр: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилье.

Байнгын хорооны гишүүдийн олонх бүрдсэн тул Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдөр энэ хуралд ирсэн гишүүдийг танилцуулъя.

Хавдисламын Баделхан гишүүн ирсэн байна. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Балжсиннямын Баярсайхан гишүүн ирсэн байна. Буланы Бейсен гишүүн чөлөөтэй байгаа. Сандагийн Бямбацогт гишүүн алга байна. Бямбацогт гишүүн энэ хуралдаа ороорой. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн байна. Баттөмөрийн Энхбаяр гишүүн цэцийн хуралтай байгаа юм байна. Тэрийгээ тараад ирнэ байх гэж бодож байна. Нямаагийн Энхболд гишүүн байна. Ширнэнбаньдын Адьяаа гишүүн хуралдаа суугаарай. Ер нь Улсын Их Хурлын гишүүдийн өөрсдийнх нь үндсэн үүрэг бол хуралд суух шүү. Адьяаа гишүүн, Бямбацогт гишүүн 2 хуралдаа сууна аа, хүлээж байна шүү.

Ингээд ирц бүрдсэн байна. Ингээд хурлаа үргэлжлүүлье. Танилцуулж дууслаа.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

“Монгол УИХ-ын 2023 оны намрын ээлжит чуулганы 5 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны төсөл

2-т нь, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ, Баярсайхан нараас 2022 оны 5 сарын 27-ны өдөр, эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хорооны тогтоолын төслийн цаглаврыг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Тараачихсан байгаа. Үүнийг ингээд баталъя. Энэ ном журмаараа юм. Баталсанд тооцож байна. Санал хураалт явуулчихъя, санал хураалт.

66.7%-ийн саналаар санал дэмжигдэж байна.

Ингээд цаглаврыг батлагдлаа.

10.48 цаг

Ажлын хэсгээ оруулаарай.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийг оруулаарай. Шуурхай явчихъя. Дараа дараагийн хурлууд байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль хамт өргөн мэдүүлсэн Бат-Эрдэнэ, Баярсайхан нарын өргөн мэдүүлсэн 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр, эцсийн хэлэлцүүлэг.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Өнөөдрийн ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Баатарзориг Төрийн албаны зөвлөлийн дарга, Бат-Эрдэнэ Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга, Сувдмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Алтанзул Удирдлагын академийн Эрх зүйн танхимын эрхлэгч доктор, Дарьхүү МУИС-ийн зөвлөх профессор, Оюунгэрэл МУИС-ийн багш, профессор. Манай ажлын дэд хэсэгт дандаа профессорууд, эрдэмтэн докторууд байж байгаа. Сайн ажилласан гэдгийг бас хэлчихье.

Ингээд би энэ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн тухай товч танилцуулгыг хийчихье. Тийм ээ.

Байнгын хорооны гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ, Баярсайхан нарын гишүүдээс өргөн мэдүүлсэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хорооноос байгуулсан ажлын хэсэгт нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгээр олонхын саналд олонхын дэмжлэг авсан нийт 25 зарчмын зөрөөтэй саналын төсөлд нэг бүрчлэн нэмж тусгаж, төслийг эцсийн хувилбарыг бэлтгэлээ.

Нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлэгт санал хурааж дэмжигдсэн Төслийн 9 дүгээр зүйлд Улсын Их Хурал төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлсэн, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг

баталж мөрдүүлнэ гэсэн хэсэг нэмэх, төслийн 10 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн Засгийн газар гэснийг Засгийн газрын Ёс зүйн дэд хороо гэж, Ёс зүйн дэд хорооны гэснийг хуулийн 13.3-д заасан гэж өөрчлөх, төслийн 16 дугаар зүйлийн 16.1.4-д заалтыг төрийн албанаас гэсний өмнө төрийн албаны тухай хуульд заасны дагуу гэж нэмэх, төслийн 20 дугаар зүйлийг хасах гэсэн саналуудыг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсэгт заасны дагуу Байнгын хорооны гишүүдийн олонхын саналаар дэмжигдэх ёстой. Түүнчлэн дээрх саналуудыг гаргасантай холбогдуулан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн 2 дугаар зүйлийн 37 дугаар зүйлийн 37.1.7 гэснийг хасах болон бусад саналууд, найруулгын шинжтэй зарчмуудыг томъёоллыг бэлтгэсэн болно.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол нэгдсэн хуралдааны хэлэлцүүлгээр олонхын санал авсан саналын төсөлд нэмж тусгах, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд тараасан болно. Хэлэлцэж шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа. Ажлын хэсэг гэсэн ийм танилцуулгыг хийж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн талаарх танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Баделхан гишүүнээр тасалъя.

Занданшатар даргын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Байнгын хорооны дарга, гишүүд, ажлын хэсгийн гишүүдэд талархал илэрхийлье. Энэ Төрийн албан хаагчийн ёс зүй сахилга хариуцлагын тухай хууль нэртэйгээр анх

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

2018 онд боловсруулж, үндсэндээ 5 дахь жилийнхээ нүүрийг үзэж байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ажиллаж байх үеэс эхлээд энэ хуулийн төслийн талаар судалж, эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллаж, манай Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баттөмөр гишүүд манлайлж энэ хуулийн эцсийн хэлэлцүүлгийг хийж байна.

Тэгэхээр энэ хуулийн зорилгыг бас тодруулж хэлэх нь зүйтэй байх гэж бодож байгаа юм.

I дүгээрт, 90-ээд оноос хойш шилжилтийн үед ардчилал, хүний эрх, эрх чөлөө дэлгэрэхэд ерөөсөө бүх зүйл бололцоотой, нээлттэй, хүний эрх хязгааргүй гэсэн ойлголтын дор хуучин бүх ёс уламжлал, зан заншлын хуулийг халж, ёс зүйн хэм хэмжээг үндсэндээ байхгүй болгосон. Гэр бүлийн харилцаанд, садар самууныг сурталчлахаас авхуулаад архидан согтуурах хүртэл энэ ёс зүйгүй зөрчлүүд улам даамжирч, энэ шилжилтийн 30 жилд төр, нийгмийн харилцаа, иргэд хоорондын харилцаанд хүртэл энэ хэм хэмжээ гэдэг юм алдагдсан. Тэгэхээр хэм хэмжээ гэдэг бол нэг улаан шугам давж болохгүй улаан шугам гэж хуульчлан тогтоогоогүй ч гэсэн ёс зүйн хэм хэмжээ зан заншлын хуулиар зохицуулагддаг байсан тэр хэм хэмжээ маань бол алдагдсан учраас нийгмийг манлайлах үүрэгтэй төрийн албанаас эхэлж, нийгэмд ёс зүйн хэм хэмжээг тогтоох ийм зайлшгүй шаардлага байна. Ийм ёс зүй алдагдсан учраас л энэ бүх шатад хулгай луйвар гаарч, гэмт хэрэг зөрчил даамжирч байгаа нэг шалтгаан болдог. Тэгээд шударгуу төр засаг ёс зүйтэй байвал нэг ч хууль гарахгүй байсан түүнийг дагаж мөрдөнө. Шударгуу ёс зүйгүй төр байвал мянган хууль ч гаргаад нэмэргүй гэсэн эртний үг бий.

Ийм учраас үүнийг ингэж ёс зүйн хэм хэмжээг сахиж мөрдүүлснээр энэ авлига, хээл хахууль бүх шатанд байгаа энэ хүнд суртал, чирэгдэл арилгахад

дэвшил гарна гэж үзэж байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ шатыг дээрээс нь эхэлж шүүрдэх хэрэгтэй. Энэ “шүүр” ажиллагаа энэ тэр бол доор нь бужигнуулахдаа биш дээрээс нь эхэлж шүүрдэх хэрэгтэй. Тийм учраас энэ хуулийн дагуу Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг хэрэгжүүлдэг механизмтай болно. Төрийн өндөр албан тушаалтнууд хамаатан садан, найз нөхөд, хамаарал бүхий этгээддээ хөнгөлөлттэй зээл авч өгөхөөр нөлөөлөх бол ёс зүйн зөрчил, ёс зүйн зөрчил зөрчсөн бол Улсын Их Хурлын гишүүнээс эргүүлэн татах хүртэл ийм хариуцлага механизмтай. Хамаатан садан, хамаарал бүхий этгээдүүдээ томилуулахаар нөлөөлөх, Үндсэн хуулийн ажил мэргэжлээ сонгох чөлөөтэй эрхийн хүрээнд ингээд чадалтай хүмүүс нь ажлаа хийж явах нь нээлттэй чөлөөтэй байх ёстой.

Харин нөлөөлж хууль бусаар дарамт шахалт үзүүлж, ийм ёс зүйн зөрчил гаргаж байгаа асуудлуудыг үүгээр хязгаарлаад ерөөсөө энэ дээрээсээ авхуулаад доороо хүртэл энэ ёс зүйн хэм хэмжээ мөрдөгдөж байж л энэ төрийн жинхэнэ мөн чанар оршиж ёс зүй оршино. Хууль сахигдана, авлига хээл хахуулиас ангижирна. Ийм учраас энэ ёс зүйн зөвлөл ажиллах асуудлыг бол хараат бусаар ажиллах механизмдаа хэрэгжүүлэх механизм хууль батлах шаардлагатай юу? Өөрөөр хэлбэл дагаж мөрдөх журмын тухай хууль гаргаад ч юм уу энэ Ёс зүйн хороо бол 3 талт байх ёстой юм шиг байна лээ. Дарга өөрөө томилоод нэг ёс зүйн хороо байгуулчихаар тэр даргыгаа яаж хянах вэ. 3 талт хороо гэдэг бол ажил олгогч, хэрэглэгчдийн төлөөлөл бас байж байж төрийн бүх шатын энэ 4232 байгууллага дээр ёс зүйг жигдлэх. Ингээд нэг нийгэм дээрээ өөрчлөлт орж, төрийн алба тэр аяараа өөрчлөлт орж байж яахгүй бол гэм зэмгүй жинхэнэ төрдөө зүтгэж байгаа төрийн албан хаагчид бас хэлмэгдэж байгаа юм. Нэр хүндийг нь унагааж байна. Төрийн албаны нэр хүндийг унагааж байна.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Цөөхөн хэдэн авлигач ёс зүйгүй хүмүүсээс болоод нийт төрийн албаны нэр хүнд унаж байгааг хязгаарлах зорилготой хууль гэж үүнийг ойлговол зохино. Ийм учраас энэ хуулийн хэрэгжилтийг онцгой анхаарах шаардлагатай. Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хэрэгжилтийн механизмыг бий болгох иж бүрэн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай. 4 мянга ... /минут дуусав/

Б.Баттөмөр: Занданшатар даргыг нэмж өгье, цаг нэмж өгье, дуустал нь.

Г.Занданшатар: Тэгэхээр төрийн албаны 4232 байгууллага байна. Тэгэхээр 4232 байгууллага дээр хүрэхэд тэр задраад төрийн 225205 төрийн албан хаагчид хүрнэ. Энэ бол үндсэндээ төрийн албан хаагчдынхаа эрх ашгийг хамгаалах, дарга удирдлагын нөлөөлөл, хууль бус дарамт шахалтаас хамгаалах тухай хууль гэж нэг талаасаа бодвол ойлгоно.

Ийм учраас энэ 4232 байгууллага дээр байгуулахын тулд энэ дээр Ёс зүйн хороо манлайлж, дээрээсээ доошоо хүртэл энэ зөв оновчтой бодлого хэрэгжүүлэх шаардлагатай. Тийм учраас энэ Ёс зүйн дэд хороо бол Засгийн газрын дэргэд ажиллахдаа зарим улсад Канад энэ төрд бол Ерөнхий сайдын дэргэд бий. Зарим улсад Хэрэг эрхлэх газрын дэргэд бий. Үүнийг тодорхой болгох. Гол нь Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороо механизмыг зөв ажиллуулах хэрэгтэй. Ингээд энэ Төрийн албаны зөвлөлийн дэргэд ажиллах Ёс зүйн хороо бол ахмад хуульчдаас, туршлагатай хүмүүсээс бүрдсэн ийм хяналтын механизм бий болгоод ингээд Монгол төрийн нэр хүндийг өндөрт өргөхөд энэ хууль чиглэгдэнэ.

Хамгийн гол нь бол энэ төрд итгэх ард түмний итгэл сулраад байгаа тэр ёс зүйгүй авир дээрээ л байгаа тэр дээрээс л хэн нэгэн дарга дарамт шахалт үзүүлж, нөлөөлөл үзүүлж байж тэр ЖДҮ ч байна

уу, Хөгжлийн банк ч байна уу, нүүрсний хулгай ч байна уу, энэ хууль бус үйлдлүүд гааль, хил дээр ингэж нөлөөлж байгаа. Тэгээд үүнийг илтгэдэг, мэдээлдэг энэ ёс зүйн зөрчил намайг дарамт шахаад байна, болохгүй байна гэдгийг ингэж мэдээлдэг энэ ёс зүйн зөвлөл ажиллаж байсан бол ийм хулгайн хэрэг зөрчлүүд гарахгүй. Энэ бол тэгэхээр хулгай зэлгийгээс урьдчилан сэргийлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, Монгол төрийн нэр хүндийг өндөрт өргөх энэ механизмыг анхан шатад хүртэл тууштай хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах дагаж мөрдөх журмын тухай хууль болон Улсын Их Хурлын тогтоол санаачлах шаардлагатай юу? Энэ чиглэлээр бид ер нь цаашидаа ахиц дэвшил хийж чадвал нийтийн алба, төрийн алба бол бас нэлээн үр дүнтэй болгох шаардлагатай.

Энэ дээр бас нийтийн алба төрийн компаниудыг яаж хамруулах вэ гэдэг ийм нэг асуулт асуудал байгаа юм. Яагаад гэхээр энэ бол төрийн албан хаагчдадаа л хамаараад байдаг. Тэгтэл 75 мянган Төрийн өмчит компанийн ажилтан ажиллагсад байна. Тэнд л бас ёс зүйн зөрчил, дарамт шахалт, янз бүрийн асуудлууд яригддаг. Ийм учраас үүнийг яаж хамруулах вэ, хамруулахдаа харин бид энэ дагаж мөрдөх журмын тухай хууль юм уу аль эсвэл хууль хэрэгжүүлэх тогтоол батлах шаардлагатай. Энэ бүхнийг нэг бас цогцоор нь шийдэх шийдэл шаардлага байна уу гэсэн ийм гол асуулт байгаа юм. Санал бас байгаа юм.

Б.Баттөмөр: Занданшатар даргад баярлалаа, санал хэллээ. Баделхан гишүүнд микрофон өгье.

Х.Баделхан: Баярлалаа. Хуулийн төслийг бол ерөнхийдөө дэмжиж байгаа. Нэлээн их яригдсан, нэлээн сайн хууль гарч байгаа гэж ингээд үзэж байгаа. Энэ хуулийн төсөл дээр өнөөдөр зарчмын зөрөөтэй санал дотор Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо гэж л орж байгаа юм байна л даа. Тэгэхээр энэ байгууллага нь ямар бүтэц

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

бүрэлдэхүүнтэй байх юм бэ? Орон тооны байх уу, орон тооны бус байх уу.

Нөгөө талаар энэ Ерөнхий сайдын дэргэд байх юм уу эсвэл хэрэг эрхлэхийн даргын дэргэд байх юм уу гэсэн нэг асуулт байна. Нөгөө талаар Төрийн албаны зөвлөл дээр ч гэсэн бас үүнтэй холбоотой ямар бүтэц бүрэлдэхүүнтэй байх юм? Яаж, хоорондоо ямар холбоотой ажиллах юм бол? Үүнийг бас нэлээн нарийн болгох хэрэгтэй.

Сая Занданшатар дарга бас хэллээ. Энэ төрийн өмчийн компаниуд гэж. Төрийн өмчийн компанийн албан хаагч нар чинь бас нэг талдаа бас төрийн албан хаагч нар шүү дээ. Энэ Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь тэр төрийн өмчийн компанийн байгууллагуудын тэр ёсыг ер нь хэлэлцэх үү, хэлэлцэхгүй юу? Энэ тал дээр ямар чиглэлтэй байгаа юм бол гэсэн асуулт байна.

Б.Баттөмөр: 1 дүгээр микрофон Алтанзул хариулъя.

Удирдлагын академийн багш Алтанзул Баделхан гишүүний эхний асуултад хариулъя. Засгийн газрын дэргэдэх дэд хороог Засгийн газар өөрт нь бид нар эрх олгож байгаа. Засгийн газар өөрөө тодорхой журмаараа Ерөнхий сайдын дэргэд байх юм уу, Хэрэг эрхлэх газрын дэргэд байх юм уу гэдгийг өөрснөө эрхлэх хүрээнийхээ асуудлаар шийднэ. Үүнийг бол нээлттэй зохицуулалтаар бол оруулж өгсөн байгаа.

2 дахь асуултын хувьд, Төрийн албаны зөвлөлийн хувьд энэ Ёс зүйн дэд хороо байгаа. Яагаад Төрийн албаны зөвлөлийн дэргэд байгуулж байна вэ гэхээр нөгөө Улсын Их Хурлаас байгуулагддаг хараат бус байгууллага. Тэгээд төрийн байгууллын эрх мэдэл хуваарилах, хяналттай, тэнцвэртэй байх энэ зарчмын дагуу энэ Ёс зүйн хороог байгуулсан байгаа. Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх байгаа энэ хороо

маань 9 гишүүнтэй. 5 нь Төрийн албаны зөвлөлийн гишүүд, орон тооны бус 4 гишүүн байгаа. Энэ бол илүү чөлөөтэй оролцоог хангасан ийм зохицуулалт орж ирсэн.

Тэгээд энэ нь бол бас тусгайлан журмаараа бас энэ зохицуулахаар орж ирсэн, бас нээлттэй, сонголттой байхаар хуульд оруулж ирсэн байгаа.

3 дахь асуултын хувьд бол яах аргагүй төрийн өмчит хуулийн этгээдүүдийн хүрээнд төрийн албан хаагчид ямар байх вэ гэхээр манай хуулийн 4 дүгээр зүйлд тодорхой зааж өгсөн. Өөрөөр хэлбэл Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан зохицуулалтын дагуу энэ хуулийн 4.2 дээр Авлигын эсрэг хуулийн 4.1.5, 4.1.7, 4.1.9-д заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна гэхээр төрийн өмчит компаниудын удирдах албан тушаалтнууд энэ хуульд хамаарна.

Б.Баттөмөр: Засгийн газарт энэ дэд хороонд хамаарна гэсэн үг байна шүү дээ, тийм ээ. Баделхан тэгж ойлгох нь байна шүү дээ. Орон тооны бус шүү дээ. Бүх дэд орон тооны бус, бүх дэд хороо. Ер нь хороо ч гэсэн 4 нь юу байгаа шүү дээ, орон тооны бус.

3 номер Сувдмаа. 3 номер Сувдмаад микрофон өгье.

Баделхан гишүүний асуултад Хэрэг эрхлэх газрын Сувдмаа хариулъя. Энэ 22 оны эцсийн дүн мэдээгээр болохоор нийтдээ 225 мянга орчим төрийн албан хаагч байгаа. Эндээс 219 мянга нь энэ гүйцэтгэх засаглалын хүрээнд буюу Засгийн газрын харьяа байгууллагуудад ажилладаг төрийн албан хаагч хаагчид байгаа. Үүн дээр нэмэх нь 75500 төрийн өмчит компаниудад ажиллаж байгаа гүйцэтгэх удирдлагын багт хамаарах энэ хүмүүс тэр Засгийн газрын Ёс зүйн хороонд ер нь үйл ажиллагаа нь хамаарах юм. Үүнтэй холбоотойгоор энэ хуулийн энэ 14.3.2-т энэ кабинетын зарчмыг харгалзан үзээд Засгийн газар нь энэ

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Засгийн газраас томилогддог холбогдох албан тушаалтан болон тэр Авлигын эсрэг хуулийн гээд 4.1.3, 4.1.5, 4.1.9-д заасан этгээдийн гэж оруулж өгөхийг хүсэлт болгож байна.

Б.Баттөмөр: Энх-Амгалан сайд яачихлаа.

Асуулт асууж, хариулт авлаа.

Одоо санал хураалт биз дээ, тийм ээ. Ингээд санал хураалт нь 3-ны 2-оор явах юм байна, дэгийн хуулиараа. Тэгээд нэг гишүүн Адышаа хаана байна.

Сайд ирлээ, баярлалаа.

Одоо санал хураагаадахъя, сайд нэг түр сууж өгөөч.

Ажлын хэсгээс зарчмын зөрөөтэй 6 санал, найруулгын 1 саналаар хураалгахаар бэлтгэсэн байна.

Ингээд Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу Байнгын хороонд оролцсон гишүүдийн 3-ны 2 нь дэмжих ёстой байгаа. Энэ зарчмын зориулалттай саналуудыг гуравны хоёроор дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

71.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.2 дахь хэсэг нэмэх:

“9.2. Улсын Их Хурал төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг баталж, мөрдүүлнэ.” гэсэн ийм санал байна. Санал хураалт явуулъя.

Баярсайхан гишүүн. Баярсайхан гишүүнээр яачихлаа. Баярсайхан гишүүн санал гаргая.

Б.Баярсайхан: Миний тоног төхөөрөмж гацсан учраас саналыг дахин явуулж өгнө үү. Баярлалаа. Саяын саналыг хүчингүйд тооцоод дахин явуулж өгнө үү.

Б.Баттөмөр: Баярсайхан гишүүний саналын дагуу саяын саналыг хүчингүйд тооцъё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

71.4 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

Дахиад санал хураалт явуулъя. Түрүүчийн санал дахиж санал хураалт явуулъя, санал хураалт.

71.4 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

Энэ санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 11 дүгээр зүйлийн 11.6.1 дэх заалтын “бодлого” гэсний дараа “, үндэсний хөтөлбөр” гэж нэмэх. Санал хураалт, санал хураалт.

Санал 71.4 хувиар дэмжигдэж байна.

3.Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Засгийн газар нь” гэснийг “Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь” гэж, “Ёс зүйн дэд хорооны” гэснийг “энэ хуулийн 13.3-т заасан” гэж өөрчлөх. Санал хураалт.

71.4 хувиар санал дэмжигдэж байна.

4.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтын “төрийн албанаас” гэсний өмнө “Төрийн албаны тухай хуульд заасны дагуу” гэж нэмэх. Санал хураалт.

Санал 71.4 хувиар дэмжигдэж байна.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

5, Төслийн 20 дугаар зүйлийг хасах.
Санал хураалт.

Уучлаарай, миний энэ юу ажилласангүй. Миний энэ аппарат ажилласангүй, санал хураалтыг хүчингүй болгохоор санал хураалт явуулж өгнө үү гэж. Санал хураалт, санал хураалт.

71.4 хувиар санал дэмжигдэж байна.

Уучлаарай, энэ саяын юу дэмжигдлээ, санал хураалт. Төслийн 20 дугаар зүйлийг хасах гэсэн томъёоллоор дахиж санал хураалт явуулъя.

Баделхан гишүүн.

Х.Баделхан: Энэ төхөөрөмж ажилласангүй, дахиж санал хураалгаж өгнө үү.

Б.Баттөмөр: Саналын дагуу дахин санал хураалт явуулъя, хүчингүй болъё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

71.4 хувиар санал дэмжигдэж байна.

5, Төслийн 20 дугаар зүйлийг хасах гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

71.4 хувиар санал дэмжигдэж байна.

Найруулгын санал.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “ажил хэргийн санаа бодлыг үл хүндэтгэх” гэснийг “ажил хэргийн саналыг үл хайхрах” гэж, 8.1.5 дахь заалтын “хясан боогдуулахгүй” гэснийг “хязгаарлахгүй” гэж, 8.2.3 дахь заалтын “мэдээллийг бусдад дамжуулах” гэснийг “мэдээллээр бусдыг гутаах” гэж, төслийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтын “Дэд хорооны” гэснийг “энэ хуулийн 15.1.5-д заасан” гэж, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын “тухайн албан

хаагчийг дуудан ирүүлж,” гэснийг “тухайн албан хаагчаас биечлэн” гэж тус тус өөрчлөх, төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “10.1.” гэсний дараа “, 10.2” гэж нэмэх, төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан” гэснийг хасах.

Санал байна уу? Алга байна, тийм ээ. Ажил хэргийг үл хайхрах гэж үл хүндэтгэх гэснийг үл хайхрах гэж, хясан боогдуулахгүй гэснийг хязгаарлахгүй байх, мэдээллийг бусдад дамжуулах гэснийг мэдээллээр бусдыг гутаах гэж.

дэд хорооны гэснийг энэ хуулийн 15.5-д заасан гэж, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын тухайн албан хаагчийг дуудан ирүүлж гэснийг тухайн албан хаагчаас биечлэн гэж тус тус өөрчлөх, төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн 10-ын 1 гэсний дараа 10-ын 2 гэж нэмэх, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн энэ хуулийн 8.1, 8.2-т гэснийг хасах гээд. Ийм байлгүй дээ, сонин юм уншигдаад байсан юм.

Санал хураалт.

Санал гаргая. Баярсайхан гишүүн; микрофон өгье.

Б.Баярсайхан: Уучлаарай, дарга аа. Миний төхөөрөмж гацсан учраас саяын саналыг хүчингүйд тооцож, санал дахин хураалгаж өгнө үү. Баярлалаа.

Б.Баттөмөр: Баярсайхан гишүүний саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё оо гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал 71.4 хувиар дэмжигдэж байна.

Энэ найруулгын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

71.4 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

1. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

Төслийн 2 дугаар зүйлийн “37 дугаар зүйлийн 37.1.7,” гэснийг хасах. Санал хураалт.

Санал 71.4 хувийн саналаар дэмжигдэж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн барьж төлсөн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хууль, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Баярсайхан гишүүн танилцуулна.

11.20 цаг

Өнөөдөр Байнгын хорооны хуралд хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон Их Хурлын гишүүд, ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

Үдээс хойш 3 цагаас чуулганы хуралдаанаар орно.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ